



ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ

2013 оны 12 дугаар сар

Гадаад худалдааны эргэлт: \$10,627 сая

Мөнгөн дүн тайлант хугацааны эцэст 10,627 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 4.5%-иар буюу 496 сая ам.доллараар буурчээ. Үүнд экспорт 112 сая ам.доллараар, импорт 384 сая ам.доллараар буурсан нь нөлөөлөв.

Жилийн өсөлтийн хурд өнгөрсөн оны мөн үеэс 3 нэгж хувиар буурсан бөгөөд үүнд экспортын жилийн өсөлт 3 нэгж хувиар, импортын жилийн өсөлт 6 нэгж хувиар буурсан нь нөлөөлжээ.

Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 52% буюу 5,486 сая ам.долларын худалдааг БНХАУ улстай, 15% буюу 1,623 сая ам.долларын худалдааг ОХУ-тай тус тус хийсэн байна. БНХАУ-тай хийсэн худалдаа өнгөрсөн оны мөн үеэс 6%-иар, ОХУ-тай хийсэн худалдаа 16%-иар тус тус буурчээ.

Гадаад худалдааны нийт тэнцэл: -\$2,082 сая

Мөнгөн дүн 2013 оны эхний 12 сарын байдлаар гадаад худалдааны тэнцэл -2,082 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 11.5%-иар буюу 272 сая ам.доллараар буурчээ. Энэ нь экспорт 3%-иар буурсан хэдий ч импорт түүнээс илүү буюу 6%-иар буурсантай холбоотой байна.

Экспорт, импортын жилийн өсөлтийн зөрүүг 3 сарын шаталсан дунджаар (moving average) авч үзвэл сүүлийн жилүүдэд байнгын бууралттай гарсан байна. Дүрслэл 1-ээс харахад экспорт, импортын жилийн өсөлтийн хурд 2011 оны 10 дугаар сараас хойш буурсан хэвээр байгаа бөгөөд 2013 оны 8 дугаар сараас эхлэн бага зэрэг өсөх хандлага ажиглагдаж байна.

Валютын төлбөртэй худалдааны тэнцэл: -\$1,647 сая

Валютаар төлбөр тооцоог нь гүйцэтгэсэн худалдааны тэнцэл нь төгрөгийн валюттай харьцах ханшинд нөлөөлдөг суурь үзүүлэлт юм.

Энэхүү үзүүлэлт 2013 оны эхний 12 сард -1,647 сая ам.долларт хүрч, тэнцлийн нийт дүн нь өнгөрсөн оны мөн үеэс 8%-иар өсчээ. Үүнд валютын төлбөртэй импортын дүн 0.3%-иар өссөн, экспортын дүн 2.6%-иар буурсан нь нөлөөлөв.


Гадаад худалдааны нөхцөл: 1.196

Монгол Улсын гадаад худалдааны нөхцөлийн индекс /2000 суурьтай/ тайлант хугацааны эцэст 1.196-д хүрч өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 15.7%-иар буурлаа. Үүнд нефтийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн орцын импортын хилийн үнэ буурч байгаа хэдий ч зэсийн баяжмал, нүүрс зэрэг голлох экспортын бүтээгдэхүүний хилийн үнэ буурч байгаа нь нөлөөлжээ.


Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	Эхний 12 сар			Өөрчлөлт			
	2013	2012	2011	2013/2012		2012/2011	
				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	10,627.4	11,123.0	11,316.8	(495.7)	-4.5%	(193.7)	-1.7%
Экспорт	4,272.7	4,384.7	4,817.5	(112.0)	-2.6%	(432.8)	-9.0%
Импорт	6,354.7	6,738.4	6,499.3	(383.7)	-5.7%	239.1	3.7%
Тэнцэл	(2,082.0)	(2,353.7)	(1,681.8)	271.7	-11.5%	(671.9)	40.0%

Дүрслэл 1. Экспорт, импортын өсөлтийн хурд /3 сарын дунджаар/



Дүрслэл 2. Валютын төлбөртэй худалдаа



Дүрслэл 3. Худалдааны нөхцөлийн индексийн өөрчлөлт



Бүтэц: 88%+ 12%

Ашигт малтмалын бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 2.4 нэгж хувиар буурч нийт экспортын 88%-ийг бүрдүүлэв.

Чулуун нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр ба баяжмал, боловсруулаагүй нефть гэсэн голлох 4 түүхий эдийн экспорт ашигт малтмалын экспортын 86%, нийт экспортын 76%-ийг тус тус эзэлж байна.

Түүнчлэн энэ 4 бүтээгдэхүүний ашигт малтмалын экспортод эзлэх хувь 4.5 нэгж хувиар, нийт экспортод эзлэх хувь 6.1 нэгж хувиар буурсан байна.

Өсөлт: -2.6%

Экспорт өнгөрсөн оны мөн үеэс 2.6%-иар буурсан бөгөөд уг бууралт нь ашигт малтмалын экспортын 5%-ийн бууралтаар тайлбарлагдаж байна. Гол нэрийн бүтээгдэхүүний ангиллаар авч үзвэл зэсийн баяжмал, төмрийн хүдэр ба баяжмал, боловсруулаагүй нефть, мөнгөжөөгүй алтны экспортын өсөлтүүд нь уг бүлгийн өсөлтийн 15%-ийг бүрдүүлжээ. Харин чулуун нүүрсний экспорт өнгөрсөн оны мөн үеэс 41%-иар буурсан нь уг бүлгийн өсөлтийг 19%-иар бууруулжээ.

Өөрчлөлт

Экспортын бүтээгдэхүүний тоо хэмжээний өсөлтөөс шалтгаалж 310.3 сая ам.доллараар өссөн бол үнийн бууралтаас шалтгаалж 422.3 сая ам.доллараар буурснаар нийтдээ 112.0 сая ам.доллараар буурсан байна.

Бүлэг тус бүрээр авч үзвэл ашигт малтмалын экспортын хувьд төмрийн хүдэр, боловсруулаагүй нефть, зэсийн баяжмал, мөнгөжөөгүй алтны тоо хэмжээ өссөнөөс шалтгаалж 502 сая ам.доллараар өсөхөөр байсан боловч чулуун нүүрс, жонш, лейцит нефелитийн экспортын тоо хэмжээ буурсанаас, мөн нүүрс, мөнгөжөөгүй алтны үнийн дүн буурсанаас шалтгаалж нийт ашигт малтмалын экспорт 795 сая ам.доллараар буурсан байна.

Ноос, ноолууран бүтээгдэхүүн болон бусад экспортын хувьд үнийн дүн болон тоо хэмжээ зэрэг өссөнөөр өмнөх оны мөн үеэс харгалзан 46 сая болон 47 сая ам.доллараар өссөн байна.

Дэлхий зах зээл дээрх түүхий эдийн үнэ

Алтны дэлхийн зах зээл дээрх үнэ 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар унц тутамд 1,201.6 хүрснээр өнгөрсөн оны мөн үеэс 28%-иар, өмнөх сараас 4.1%-иар буурсан байна.

А зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон цайрын үнэ 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 7,375.7, 2,053.0 ам.долларт хүрч өнгөрсөн сарын мөн үеэс харгалзан 5%-иар, 10%-иар өссөн бол өмнөх сараас зэс 6.7%-иар буурч, цайр 0.2%-иар өссөн байна.

Хүснэгт 2. Экспортын барааны гүйцэтгэл (сая ам.доллар)

	2013			2012			Өөрчлөлт		
	Тоо/хэм (мян.тн,кг)	Дүн	%	Тоо/хэм (мян.тн,кг)	Дүн	%	Дүн	%	% 2
1. Ашигт малтмал		3,776	88%		3,982	91%	(205)	-5%	-5%
Чулуун нүүрс	18,188	1,116	26%	20,547	1,880	43%	(764)	-41%	-19%
Зэсийн баяжмал	650	949	22%	574	839	19%	110	13%	3%
Төмрийн хүдэр/баяж.	6,724	654	15%	6,416	533	12%	122	23%	3%
Боловсруулаагүй нефть	5,244	515	12%	3,568	336	8%	179	53%	5%
Цайрын хүдэр ба баяж.	131	119	3%	141	131	3%	(12)	-9%	0%
Мөнгөжөөгүй алт	7,559	310	7%	2,797	122	3%	188	153%	5%
Жонш, лейцит, нефелинт	338	83	2%	429	103	2%	(19)	-19%	0%
Молибдений хүдэр/баяж	4	29	1%	4	38	1%	(9)	-23%	0%
2. Ноос, ноолуур		244.9	6%		193.2	4%	52	27%	1%
Ямааны угаа.ноолуур	4,070	189	4%	3,608	145	3%	43.4	30%	22%
Ямааны сам.ноолуур	564	56	1%	533	48	1%	8.3	17%	4%
3. Бусад		251	6%		210	5%	42	20%	1%
Нийт дүн		4,273			4,385		(112.0)	-2.6%	

% 2 - Өсөлтөө оруулсан хувь нэмэр (contribution to the growth)


Дүрслэл 4. Чулуун нүүрсний экспорт, зах зээлийн үнэ (ам.доллар)



Хүснэгт 3. Экспортын барааны өөрчлөлт (сая ам.доллар)

	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
1. Ашигт малтмал	264		(469)		(205)	
Чулуун нүүрс	(216)	28%	(549)	72%	(764)	-41%
Зэсийн баяжмал	110	100%	0	0%	110	13%
Төмрийн хүдэр ба баяжмал	26	21%	96	79%	122	23%
Боловсруулаагүй нефть	158	88%	22	12%	179	53%
Цайрын хүдэр ба баяжмал	(9)	79%	(2)	21%	(12)	-9%
Мөнгөжөөгүй алт	208	111%	(21)	-11%	188	153%
Жонш, лейцит, нефелинт	(10)	52%	(9)	48%	(19)	-19%
Молибдений хүдэр ба баяжмал	(3)	33%	(6)	67%	(9)	-23%
2. Ноос, ноолуур	23		28		52	
Ямааны угаасан ноолуур	18.6	43%	24.8	57%	43.4	30%
Ямааны самнасан ноолуур	4.7	56%	3.6	44%	8.3	17%
3. Бусад	23	56%	18	44%	42	20%
Нийт	310.3		(422.3)		(112.0)	

Дүрслэл 5. Дэлхийн зах зээл дээрх алт, цайр, зэсийн үнэ



Бүтэц: 24% + 22%

2013 оны эхний 12 сарын байдлаар нийт импортын 46%-ийг үйлдвэрлэлийн орц болон нефтийн бүтээгдэхүүн, 11%-ийг өргөн хэрэглээ, 3%-ийг хүнсний бараа, үлдсэн 40%-ийг бусад төрлийн импортын бүтээгдэхүүн эзэлж байна.

Үйлдвэрлэлийн орц, нефтийн бүтээгдэхүүний импортын нийт импортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 2 нэгж хувиар буурсан нь үйлдвэрлэлийн орцын хувийн жин 3.3 нэгж хувиар буурсантай холбоотой байна. Харин өргөн хэрэглээ, хүнсний бүтээгдэхүүний эзлэх хувь өөрчлөлт багатай, тогтвортой хэвээр байна.

Өсөлт: -5.7%

Импортын 5.7%-ийн бууралтыг ерөнхий ангиллаар задалвал үйлдвэрлэлийн орцын бууралт нь 5%-ийг, өргөн хэрэглээний импортын бууралт 1%-ийг тус тус тайлбарлаж байна.

Үйлдвэрлэлийн орц өмнөх оноос 17%-иар буюу 316 сая ам.доллараар, өргөн хэрэглээний импорт өмнөх оноос 8%-иар буюу 67 сая ам.доллараар буурсан нь нийт импортийг 5.7%-иар буурахад голлон нөлөөлжээ.

Өөрчлөлт

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад импорт нь тоо хэмжээний бууралтаас шалтгаалан 156 сая ам.доллараар, үнийн дүнгийн бууралтаас шалтгаалан 228 сая ам.доллараар, нийт дүнгээр 384 сая ам.доллараар буурчээ.

Нефтийн бүтээгдэхүүний импорт тоо хэмжээний өсөлтөөс шалтгаалан 46.3 сая ам.доллараар өссөн хэдий ч хилийн үнийн бууралттай холбоотойгоор үнийн дүн нь 30.9 сая ам.доллараар буурсанаар нийт 15.4 сая ам.доллараар өссөн байна. Дүрслэл 6-с үзэхэд хилийн үнэ 2012 оны эхнээс буурч, 8 сараас өсөх хандлагатай байсан хэдий ч 2013 оны 1 дүгээр сараас эхлэн буцаад буурч байна.

Үйлдвэрлэлийн орцын бууралтын 72% нь тоо хэмжээний, 28% нь үнийн дүнгийн бууралтаас шалтгаалж нийт дүнгээр 316 сая ам.доллараар буурсан байна. Өргөн хэрэглээний бүтээгдэхүүний 69% нь тоо хэмжээний, 31% нь үнийн дүнгийн бууралтаас шалтгаалж нийтдээ 67 сая ам. доллараар буурчээ.

Зарим хэрэглээний барааны импорт*

Голлох хэрэглээний барааны импортын 3 сарын гулсах дунджаар тооцсон жилийн өсөлт тайлант хугацааны эцэст 8% -д хүрч буурсан байна.

Цахилгаан барааны жилийн өсөлтийн хувьд 2012 оны дунд үеэс буурч байсан хэдий ч 2013 оны 8 дугаар сараас эхлэн өөрчлөлт багатай, тогтвортой байна. Харин суудлын автомашины импортын өсөлт жилийн өсөлтийн түвшин 2013 оны 8 дугаар сараас эхлэн буурах хандлагатай байна. Ингэснээр нийт өргөн хэрэглээний импорт 2013 оны 8 дугаар сараас эхлэн буураад байна.

* Нийт импортын 70%-ийг бүрдүүлдэг 136 бүтээгдэхүүнээс өргөн хэрэглээний гэсэн 48 бүтээгдэхүүний хувьд тооцоолов.

Хүснэгт 4. Импортын барааны гүйцэтгэл (сая ам.доллар)

Төрөл	2013			2012			Өөрчлөлт		
	Тоо/хэм (тн,мян.ш)	Дүн	%	Тоо/хэм (тн,мян.ш)	Дүн	%	Дүн	Хувь	Хувь2
Үйлдвэрлэлийн орц		1,502	24%		1,817	27%	(316)	-17%	-5%
Хүнд механизм, тоног төх.	3,299	897	60%	12,542	1,113	61%	(216)	-19%	-12%
Суудлаас бусад автомашин	1,110	438	29%	1,030	546	30%	(108)	-20%	-6%
Төмөр хийц, металл бүт.	48,426	70	5%	35,056	55	3%	16	29%	1%
Бусад бүтээгдэхүүн	123,312	96	6%	581,791	104	6%	(8)	-8%	0%
Нефть		1,409	22%		1,394	21%	15	1%	0%
Дизель түлш	756,149	860	61%	716,483	820	59%	40	5%	3%
АИ-92, АИ-95	273,482	324	23%	255,182	325	23%	(1)	0%	0%
А-80 болон бусад	180,451	225	16%	192,149	249	18%	(24)	-10%	-2%
Өргөн хэрэглээ		730	11%		798	12%	(67)	-8%	-1%
Суудлын автомашин	45	373	51%	46	430	54%	(57)	-13%	-7%
Цахилгаан бараа	1,032	152	21%	1,067	155	19%	(3)	-2%	0%
Бүх төрлийн эм	2,162	72	10%	2,155	77	10%	(5)	-6%	-1%
Бусад өргөн хэрэглээний	16,669	133	18%	17,564	136	17%	(2)	-2%	0%
Хүнс		188	3%		205	3%	(16)	-8%	0%
Гурил, будаа, талх	59,141	51	27%	100,810	66	32%	(14)	-22%	-7%
Сүү, сүүн бүтээгдэхүүн	4,099	17	9%	4,801	18	9%	(1)	-8%	-1%
Төрөл бүрийн өөх тос	27,624	35	19%	25,168	33	16%	2	7%	1%
Согтууруулах ундаа	35,803	32	17%	32,034	33	16%	(1)	-3%	-1%
Хүнсний ногоо	61,344	13	7%	76,370	14	7%	(1)	-4%	0%
Бусад	66,014	40	21%	67,415	41	20%	(1)	-3%	-1%
Бусад импорт		2,525	40%		2,525	37%	(0)	0%	0%
Бусад		2,525			2,525		(0)	0%	0%
Нийт дүн		6,355			6,738		(384)	-5.7%	-5.7%

% 2 - Өсөлтийг оруулсан хувь нэмэр (contribution to the growth)

Дүрслэл 6. Нефтийн бүтээгдэхүүний импорт, хилийн дундаж үнэ



Хүснэгт 5. Импортын барааны өөрчлөлт (сая ам.доллар)

Төрөл	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн дүнгийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн дүнгийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
Үйлдвэрлэлийн орц	(226.6)	72%	(89.0)	28%	(315.5)	
Хүнд механизм, тоног төх.	(231.1)	107%	15.3	-7%	(215.7)	-19%
Суудлаас бусад автомашин	(3.2)	3%	(104.4)	97%	(107.7)	-20%
Төмөр хийц, металл бүт.	10.3	65%	5.6	35%	15.9	29%
Бусад бүтээгдэхүүн	(2.6)	32%	(5.5)	68%	(8.1)	-8%
Нефть	46.3	300%	(30.9)	-200%	15.4	
Дизель түлш	45.4	113%	(5.1)	-13%	40.3	5%
АИ-92, АИ-95	23.3	-2559%	(24.2)	2659%	(0.9)	0%
А-80 болон бусад	(22.4)	94%	(1.5)	6%	(23.9)	-10%
Өргөн хэрэглээ	(46.1)	69%	(20.9)	31%	(67.0)	
Суудлын автомашин	(37.1)	65%	(19.8)	35%	(56.9)	-13%
Цахилгаан бараа	1.0	-33%	(3.9)	133%	(2.9)	-2%
Бүх төрлийн эм	(6.4)	130%	1.5	-30%	(5.0)	-6%
Бусад өргөн хэрэглээний	(3.6)	159%	1.3	-59%	(2.2)	-2%
Хүнс	59.8	-368%	(76.1)	468%	(16.3)	
Гурил, будаа, талх	(12.7)	89%	(1.6)	11%	(14.3)	-22%
Сүү, сүүн бүтээгдэхүүн	(2.6)	185%	1.2	-85%	(1.4)	-8%
Төрөл бүрийн өөх тос	1.3	55%	1.1	45%	2.4	7%
Согтууруулах ундаа	73.1	-6895%	(74.2)	6995%	(1.1)	-3%
Хүнсний ногоо	0.5	-95%	(1.1)	195%	(0.6)	-4%
Бусад	0.2	-12%	(1.5)	112%	(1.3)	-3%
Бусад импорт	10.9	-4307%	(11.2)	4407%	(0.3)	
Бусад	10.9	-4307%	(11.2)	4407%	(0.3)	0%
Нийт дүн	(155.6)		(228.0)		(383.7)	

Дүрслэл 7. Хэрэглээний импортын хандлага /3 сарын гулсах дундаж*

